



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/04

Сүхбаатар сум

Хорио цээрийн дэглэмийг цуцалж,  
хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 2.1, 2.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын Шуурхай штабын даргын 2021 оны "Ажил эрчимжүүлэх тухай" 11134 тоот, аймгийн Онцгой комиссын 2022 оны хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхонтуул, Орхон, Сайхан сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зорилгоор тогтоосон Хорио цээрийн дэглэмийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр цуцалж, мөн өдрөөс эхлэн Хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Гоц халдварт шүлхий өвчний хорио цээр, хязгаарлалт тогтоосон сумдад холбогдох журам, зааварт тусгагдсан арга хэмжээг чанд сахиулж, эрсдэл бүхий эрүүл бүс нутагт шүлхий өвчний талаарх сэрэмжлүүлгийг иргэдэд тогтмол хүргэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, бэлэн байдлын төлөвлөгөө, хүн, хүч, халдвар хамгааллын хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөц бэлэн байдлыг хангаж, зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлж байгаа болон дамжин тархах эрсдэл бүхий нутаг дэвсгэрт уралдаан, тэмцээн, олон хүн цугларсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг үүрэг болгосугай.

6.Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж, дэглэмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Баттүвшин), Цагдаагийн газрын дарга (хурандаа Б.Ганхуяг), Онцгой байдлын газрын дарга (хурандаа Г.Галбадрах), Мал эмнэлгийн газрын дарга (С.Ариунтөгс) нарт тус тус үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга, аймгийн Засаг даргын орлогч (Ц.Рэгзэдмаа)-д даалгасугай.



Н.ЛХАГВАДОРЖ

430910002